

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 05 өдөр


Дугаар 23/20
Улаанбаатар хот

ХАЛААСНЫ ХУВЬЦААГ ДАХИН ГАРГАХ ЗАМААР АЖИЛТНУУДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7, 33.8, 76 дугаар зүйлийн 76.1.4, АПУ ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.22.3 дахь хэсэг, АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- АПУ компанийн 100 жилийн ойг утган АПУ ХК-ийн 1,206,810 ширхэг халаасны хувьцааг дахин гаргах замаар АПУ ХК болон түүний охин компаниуд (хамтад нь “Компани” гэх)-ын нийт ажилтнуудыг урамшуулж, хаалттай хүрээнд эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй.
- “Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
- Нэг ширхэг халаасны хувьцааны зах зээлийн үнийг арилжааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханшаар тогтоосугай.
- Халаасны хувьцааг эргэлтэд дахин гаргах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авч, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан холбогдох дүрэм, журмын дагуу хаалттай хүрээнд ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх бүртгэлийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хийлгүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжоор шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, холбогдох төрийн байгууллага болон үнэт цаасны компаниудтай гэрээ байгуулах, шаардлагатай зардлыг гаргаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт даалгасугай.

ГАРЫН ҮСГИЙГ ДАРААГИЙН ХУУДСААР БАТАЛГААЖУУЛАВ

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Зөвшөөрсөн УДИРДАХ ЗАГАР ХОТ "АЛУ" ХК-ийн ТӨЛӨӨЛӨЛТ СҮНЧИН	Татгалзсан	Түдгэлzsэн
1	П.Батсайхан			
2	Б.Батбаяр			
3	Сергей Громов			
4	Кеннет Чу			
5	Сэн И-ИН-			
6	Д.Миеэгомбо			
7	Ё.Гэрэлчулун			
8	О.Одбаяр			
9	Ж.Үнэнбат			

**APU JSC
BOARD OF DIRECTORS RESOLUTION**

Date: 05 December 2023

No. 23/20

Ulaanbaatar

**REISSUANCE OF TREASURY SHARES FOR
EMPLOYEE STOCK GIVEAWAY**

Pursuant to clauses 33.7, 33.8 and 76.1.4 of the Company Law of Mongolia and paragraphs 5.2 and 7.22.3 of the Charter of APU JSC and based on the decision by APU JSC Board of Directors meeting, it is hereby **RESOLVED** to:

1. Approve the reissuance of 1,206,810 treasury shares in APU JSC through private placement for the purpose of valuing and incentivizing all employees of APU JSC and its subsidiaries (collectively, "the Company") in advance of the 100th anniversary of APU Company taking place;
2. Approve the Employee Stock Giveaway Program as per annex hereto;
3. Set the market value of a treasury share to be an average price of APU stock at which it has been traded over a period of prior 52 weeks;
4. Assign CEO Ts.Erdenebileg to obtain approval for the reissuance of treasury shares from the Financial Regulatory Commission and ensure that the employee stock ownership is registered under applicable rules and procedures through Central Securities Depository ("CSD") within the first quarter of 2024; and
5. Direct CEO Ts.Erdenebileg to take all actions required under applicable laws, including, but not limited to, signing agreements with relevant government agencies and securities companies, and provide required expenses to implement this resolution.

Nº	Director	For	Against	Abstain
1	P.Batsaikhan			
2	B.Batbayar			
3	Sergey Gromov			
4	Kenneth Choo			
5	Seng Yi-Ying			
6	D.Miyegombo			
7	Yo.Gerelchuluun			
8	O.Odbayar			
9	J.Unenbat			

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 12-р сарын 05-ны өдрийн хурлын
23/20 тоот тогтоолын хавсралтаар батлав.

**АПУ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН
АЖИЛТНУУДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. АПУ ХК болон түүний охин компаниуд болох АПУ Трейдинг ХХК, АПУ Дэйри ХХК, Спирт бал бурам ХХК, СББ Трейд ХХК, М Би Си Азия Пасифик ХХК (цаашид хамтад нь 'Компани' гэх)-ийн Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (цаашид 'Хөтөлбөр' гэх) нь АПУ компанийн түүхт 100 жилийн ойг угтан хэрэгжүүлж буй ажилтанд чиглэсэн урамшууллын хөтөлбөр юм.
- 1.2. Тус хөтөлбөрийг АПУ ХК-ийн халаасны хувьцааг дахин гаргах замаар хэрэгжүүлэх бөгөөд халаасны хувьцааг эргэлтэд дахин гаргах үйл ажиллагаа нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжуудад нийцсэн байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

- 2.1. Хөтөлбөрийн зорилго нь үнэнч ажилтны үнэ цэнийг урамшуулахад чиглэх бөгөөд ажилтнуудыг тогтвортой ажиллах урам зориг өгөх, ажилтан бүрийг компанийн эзэд-хувьцаа эзэмшигч болгох, ажилласан жилээс хамаарч ялгамжтай байдлаар хувьцаа эзэмшүүлж, компанийн 100 жилийн хамтын өсөлт, үнэ цэнийг ажилтнуудтайгаа хуваалцахад оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, хамрах хүрээ

- 3.1. Хөтөлбөрт компанийд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж буй "үндсэн ажилтнууд" хамрагдах бөгөөд компанийд ажилласан жилээс хамаарч дараах нөхцөлөөр АПУ ХК-ийн халаасны хувьцаанаас эзэмшүүлнэ:
 - 3.1.1. 1 хүртэл жил ажилласан ажилтанд 30 ширхэг;
 - 3.1.2. 1-ээс дээш жил ажилласан ажилтанд "тухайн ажилтны ажилласан жилийг 100-аар үржүүлэн" хувьцаа олгох;
 - 3.1.3. Ажилтанд эзэмшүүлэх хувьцааг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар тусгаарлах.
- 3.2. Хөтөлбөрт хамрагдах ажилтны нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тогтоож, холбогдох ажилтнуудын нэрс, эзэмшүүлэх энгийн хувьцааны тоо ширхэг зэрэг мэдээллийг агуулсан жагсаалтыг энэхүү хөтөлбөрийн хавсралтаар батлав.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

- 4.1. Батлагдсан хөтөлбөрийн дагуу халаасны хувьцааг эргэлтэд дахин гаргах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хандан гаргаж, холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд шийдвэрлүүлж зөвшөөрөл гарсны дараа хэрэгжүүлнэ.
- 4.2. Батлагдсан болон зөвшөөрөгдсөн хөтөлбөрийг нийт ажилтнуудад болон Монголын хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх бөгөөд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК (цаашид 'ҮЦТХТ' гэх)-тай гэрээ байгуулсны үндсэн дээр ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх ажиллагаа хийгдэнэ.

- 4.3. Ажилтан бүрд үнэт цаасны компаниар дамжуулан үнэт цаасны данс нээлгэх бөгөөд ҮЦТХТ-тай байгуулсан гэрээний дагуу ажлын хөлс, холбогдох шимтгэл зэргийг компани хариуцан төлнө.
- 4.4. Хөтөлбөрийн хавсралтаар батлагдсан жагсаалтын дагуу ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх бүртгэлийг ҮЦТХТ хийснээр энэхүү хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусна.

Тав. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

- 1.1. Энэхүү хөтөлбөр нь АПУ ХК-ийн анх хувьцааг халаасалсан зорилгод нийцсэн бөгөөд ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэхэд чиглэсэн юм.
- 1.2. Хөтөлбөрийн хүрээнд АПУ ХК-ийн халаасны бүх хувьцааг эзэмшүүлэх тул дахин үргэлжлэх шинжгүй, нэг удаагийн хөтөлбөр юм.
- 1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд ТУЗ-ийн ажлын алба хяналт тавьж ажиллана.

---ООО---